



ДОРНОГОВЬ АЙМАГ
“ЧАНДМАНЬ-ИЛЧ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/34

Сайншанд сум

Журам батлах тухай

Монгол Улсын Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6.4 дэх заалт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нэгдсэн менежментийн тогтолцооны стандарт нэвтрүүлэхтэй холбогдуулан "Ослын шалтгаан тодорхойлох журам"-ыг 01 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан журмыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, хэрэгжилтийг хангаж ажиллахыг нийт хэлтэс, хэсгийн инженер, салбарын дарга нарт даалгасугай.

3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер (Х.Бариадбаасанжав)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ ДЭРДЭНЭБАЯР



441919081

Захирлын 2024 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн
А/34 тоот тушаалын хавсралт



“ОСЛЫН ШАЛТГААН ТОДОРХОЙЛОХ” ЖУРАМ

НЭГ. ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ БОЛОН ХЭРЭГЛЭЭ

1.1. Энэхүү журмын зорилго нь нэгдсэн менежментийн тогтолцоонд ослын дараах шалгалтын үйл явцыг тодорхойлоход оршино.

1.2. Энэхүү журам нь Чандмань Илч ХХК-ийн хэлтэс, хэсэг, салбаруудад хамаарна.

1.3. Хэрэглэгчид нь нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээнд Чандмань Илч ХХК-ийн нийт ажилтнууд юм.

ХОЁР. ОСЛЫН ДАРААХ ШАЛГАЛТ

3.1. Осол гарсан тохиолдолд Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг (цаашид ҮОХХ) судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс нь ослын шалгалтыг цаг тухайд нь хийж, үр дүнг баримтжуулах үүрэгтэй.

3.2. Хэрэв ослын шалгалтыг эрх бүхий албан тушаалтан хийх ёстой бол цаашид хийгдэх бүх үйлдлийг тэдний шаардлага болон зааврын дагуу хийнэ.

3.3. Ослын талаар тайлагнах

3.3.1. Ослын шалгалтанд ямар нөхцөл байдал, юуг илүү чухалчлахыг тодорхойлохдоо ҮОХХ-ыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын гишүүд дараах зүйлсийг харгалзан үзэх ёстой.

3.3.1.1. Ослын бодит үр дүн ба үр дагавар

3.3.1.2. Ижил төстэй ослуудын давтамж болон тэдгээрийн гаргаж болзошгүй үр дагавар

3.3.2. Ажилтан ослын талаар өөрийн нэгжийн удирдлага, ХАБЭА-н инженерт улмаар ҮОХХ-ыг судлан бүртгэх комиссын гишүүдэд мэдээлнэ.

Осол гэдэг нь том болон бага хэмжээний аваар, онцгой байдал, осолд дөхсөн тохиолдол, эрүүл мэнд муудах болон бусад тохиолдлын өртөлтүүд зэрэг байдаг.

3.4. Ослын дараах шалгалтын зорилтууд:

3.4.1. Үл тохирол, осол болон аваарыг шалгах ҮОХХ-ыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс болон компанийн удирдлагаас шийдвэр гаргахад дараах зүйлүүд тусална.

3.4.1.1. Залруулах арга хэмжээ авсанаар дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх

3.4.1.2. Дахин давтагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд илэрсэн алдаанаас суралцах

3.4.1.3. ХАБЭА-н үндсэн алдаануудыг тодорхойлох

3.4.1.4. Цаашид үүнтэй холбоотой алдаа давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор менежмент, үйл ажиллагааны практик үйл ажиллагааг эргэн харах

3.4.1.5.Байнгын сайжруулалт хийх боломжийг тодорхойлох

3.5.Ослын шалтгааныг тодорхойлох, дүн шинжилгээ хийх

3.5.1.ҮОХХ-ыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс нь ослын үндэс суурийг олж илрүүлэх зорилгоор, боломжит шалтгааныг тодруулах замаар ослын шалгах ажиллагааг эхлүүлдэг.

3.5.2.Ослын газар ирж осол үүсгэсэн байж болох бүх шалтгаануудыг нэг бүрчлэн тодорхойлж жагсаалт гаргана.

3.5.3.Ослын жинхэнэ шалтгаан болж чадах нотолгоо болон өгөгдөлд дүн шинжилгээ хийнэ.

3.5.4.Боломжит шалтгааныг хооронд нь харьцуулж аль нь хамгийн өндөр магадлалтай болохыг тогтооно.

3.5.5.Осолд хөтөлж болох нөхцөл байдал эсвэл үйл явдлын давтамж зэргийг судалж тодорхойлно. Хэрэв үндэс, суурь нь баримтаар нотлогдоогүй бол үүнийг цаашид авч үзэхгүй. Хэрэв үндэс, суурь нь баримтаар нотлогдсон бол энэ нь боломжит шалтгаан болно.

3.5.6.Ослыг шууд үүсгэж байгаа үйл явдал эсвэл тохиолдолын эх үүсвэрийг тодорхойлно. Хэрэв нэгээс олон шалтгааныг олж тогтоосон бол аль нь жинхэнэ бодит шалтгаан болохыг тодорхойлохын тулд тус бүрийг шинжилж үзэх шаардлагатай.

3.5.7.Жинхэнэ шалтгааныг судлахын тулд дараах алхамуудыг хэрэгжүүлдэг:

3.5.7.1.Физик (биет) судалгаа

3.5.7.2.Нөхцөл байдал давтаж байгаа эсэхийг тодорхойлох үйл явцыг ажиглах, ослыг идэвхижүүлэх механизмыг тодорхойлохыг хичээх

3.5.7.3.Хяналтанд байгаа орчинд юу болж байгааг үнэлэх

3.5.7.4.Энэ ослыг юу өдөөснийг харж байж болзошгүй гэрчүүдтэй ярилцлага хийх

3.5.7.5.Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, технологийн дамжлагын талаар сайн мэддэг, түүний талаар ойлголттой мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх

3.5.8.Шалгалтын дараа ҮОХХ-ыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс нь ослын шалгалтын тайлан гаргаж комиссын дарга компанийн ХАБЭА-н зөвлөлд танилцуулах.

3.5.9.Ослын шалгалтын тайлангийн дагуу тухайн нэгжийн удирдлага нь үл тохирол, залруулах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг удирдах журмын дагуу залруулга хийх.

3.6.Ослын шалгалтын дараах хийх алхамууд

3.6.1.Нэгжийн удирдлага нь тухайн ажлын байр хариуцагчийн хамт залруулга хийх арга хэмжээг авч, хэрэв шаардлагатай тохиолдолд шинэ арга хэмжээг эхлүүлнэ.

3.6.2.Шалгалтын үр дүнг ХАБЭА-н инженер болон хяналтын хэлтэст хүргүүлэх ба менежментийн дүн шинжилгээний оролт болно.

3.7.Ослын шалгалтын тайлан

Ослын талаарх ерөнхий мэдээлэл			
Ослын талаарх товч тодорхойлолт:			
Осол гарсан огноо болон цаг			
Осол гарсан газар, байршил			
Осолд оролцогсод			
Нэр	Ажлын байр	Өмнөх гэмтэл	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
Гэрч:			
Нэр		Ажлын байр	
Гэмтлийн тодорхойлолт		*	
Тоног төхөөрөмжинд учирсан хохирлын (эвдрэл) тодорхойлолт			
II Үйл явдлын давтамж			
*			
III Ослын шалтгаан			
*			
IV Эхлүүлсэн залруулах арга хэмжээ:			
*			
*			
Анализ хийсэн:		Магадлан шалгасан:	
Огноо:		Огноо:	
Залруулгын арга хэмжээ авах хүсэлт гаргасан огноо		Залруулгын арга хэмжээний хүсэлтийг магадлан шалгасан:	

ҮОХХ-ыг судлан бүртгэх комиссын дарга

Танилцсан: Захирал

[нэр] [гарын үсэг]

[нэр] [гарын үсэг]